



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

Г "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Хорооны 2016 оны 147 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам /цаашид журам гэх/"-ын 4.3 дахь хэсгийн "...дотор" гэсний дараа ", 4.3.6-д заасан тайланг зээлийн өрийн үлдэгдэл, зээлийн чанарын багцын хамт сар бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор" гэж нэмсүгэй.

2. Журмын 4.4 дэх хэсгийн ".../хавсралт 14/-ийг улирал" гэснийг "/хавсралт 13/-ыг сар, улирал" гэж өөрчилсүгэй.

3. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг дээрх журмын дагуу тооцож, мөрдөж ажиллах, холбогдох санхүүгийн тайланг улирал (сар) бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлж байхыг банк бус санхүүгийн байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН